



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/212

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтууд тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Туркийн Олон Улсын хамтын ажиллагаа, хөгжлийн удирдах газар буюу ТИКА-тай хамтран ажиллах хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хот дахь хөтөлбөр зохицуулах газрын дарга Устаөмэр Эмрах, Төслийн ассистент менежер П.Нямбаяр, Туркийн бизнесмэн Ө.Өзкан нартай хийсэн уулзалтын зардалд 427 350 төгрөг, Монгол Улсын Баруун бүс-Оросын боловсролын анхдугаар үзэсгэлэн-2019 арга хэмжээний хүрээнд Оросын Холбооны Улсын Алтайн хязгаар, Алтайн БНУлс, БНТува улсын их дээд сургуулийн төлөөлүүдтэй зохион байгуулсан уулзалтын зардалд 586 300 төгрөг, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл С.Клечески, АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны дарга Роб Тэйт нар Ховд аймагт ажлын айлчлал хийх үеээр аймаг орон нутгийн удирдлагууд хүлээн авч уулзан орон нутгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлынхаа талаар танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцох арга хэмжээний зардалд 1 005 780 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 019 430 төгрөг /Хоёр сая арван есөн мянга дөрвөн зуун гучин/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



02.010/1
DZax-A212-Ба